Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	142109.0	149680.2	7571.2
Авто тээврийн хэрэгсэл	2687.7	3507.4	819.7
Машин тоног төхөөрөмж	8047.6	11791.7	3744.1
Тавилга, эд хогшил	2931.7	3715.1	783.4
Зам, гүүрний байгууламж	4873.1	4842.0	-31.1
Түүх соёлын дурсгалт зүйлс	4546.7	4555.0	8.3
Бусад үндсэн хөрөнгө	5906.4	6984.7	1078.3
Дуусаагүй барилга, байгууламж	723.9	723.9	
Ном	1358.3	1426.3	68.0
Программ хангамж	53.3	44.7	-8.6
Бусад биет бус хөрөнгө	9765.5	10289.8	524.3
Дүн	183003.1	197560.8	14557.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	155679.8	164727.9	9048.1
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	27323.3	32832.9	5509.6
Дүн	183003.1	197560.8	14557.7

Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө данс төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2174.8 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 8647.1 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 9243.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 8599.8 сая, акталсан 1236.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга, байгууламжийн үлдэгдэл 723.9 сая төгрөг байгаа нь Наранбулаг, Өмнөговь, Улаангом сумдын Засаг даргын тамгын газар болон Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ газарт бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Залруулга

- Шинэ Улаангом ОНӨААТҮГ 0.5 сая, Чандмань-Увс ХХК 4.0 сая, Улаангом сумын Ерөнхий боловсролын 3-р сургууль 4.6 сая, Улаангом сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль 2.9 сая, Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль 0.4 сая, Сагил сумын Эрүүл мэндийн төв 0.3 сая, Зүүнхангай сумын Соёлын төв 1.0 сая, Тэс сумын Соёлын төв 1.0 сая, Завхан сумын Соёлын төв 1.1 сая, Давст сумын Засаг даргын тамгын газар 4.0 сая, Өлгий сумын Соёлын төв 1.0 сая, Хяргас сумын Соёлын төв 1.0 сая, нийт 2 компани, 9 төсвийн шууд захирагч, 1 сан 21.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- Улаангом сумын Соёлын төв 1.0 сая, Өмнөговь сумын Засаг даргын тамгын газар 411.8 сая, Сагил сумын Соёлын төв 1.0 сая, Бөхмөрөн сумын Соёлын төв 1.1 сая, Хүүхдийн цэцэрлэг 2.2 сая, Зүүнхангай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 4.5 сая, Засаг даргын тамгын газар 177.6 сая, Давст сумын Соёлын төв 1.0 сая, Тариалан сумын Ерөнхий боловсролын сургууль 1.7 сая, Хархираа бага сургууль 0.4 сая, Соёлын төв 1.1 сая, Ховд сумын Соёлын төв 1.2 сая, Өмнөговь сумын Соёлын төв 1.0 сая, Зүүнхангай сумын

- Хүүхдийн цэцэрлэг 6.8 сая, Эрүүл мэндийн төв 21.3 сая, нийт 15 төсвийн шууд захирагч 633.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд буруу дүнгээр бүртгэсэн,
- Улаангом сумын Засаг даргын тамгын газар авто зогсоол, худгийн 160.7 сая төгрөгийн дахин үнэлгээг буруу илэрхийлсэн,
 - Бөхмөрөн сумын Хүн эмнэлэг 17.3 сая, Зүүнхангай сумын Цэцэрлэг 3.5 сая, Зүүнговь сумын Соёлын төв 4.0 сая, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 40.1 сая, нийт 4 төсвийн шууд захирагч үндсэн хөрөнгийн элэгдлийг 64.9 сая төгрөгөөр дутуу, Тариалан сумын Цэцэрлэг 201.2 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн,
 - Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн тайланд нэгтгэгдсэн Завхан сумын эмийн эргэлтийн сангийн урьд онд 0.4 сая төгрөгөөр худалдан авсан программын үнийг тайлант онд худалдан авснаар мөнгөн гүйлгээний тайланд тусгасан байсныг тус тус залруулга хийлгэсэн.

Зөвлөмж

- Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал худалдан авах ажиллагааны шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг байхаар заасныг зөрчин 17.7 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, аймгийн Номын сан 19.0 сая төгрөгөөр ном шууд худалдан авалт хийсэнд зөвлөмж өглөө.

Албан шаардлага

- Тэс сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Соёлын төвийн тайзны хөшиг, тайзны хаалт, теле хяналтын төхөөрөмж, нийт 21.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- Өмнөговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 16.2 сая төгрөгийн ажлуудыг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, худалдан авах гэрээнд техникийн тодорхойлолт байхгүй, бараа материалын ширхэг, нэр төрлийг тусгаагүй байхад ажлын гүйцэтгэлийг үнэлж, үе шаттайгаар санхүүжүүлэхгүйгээр гүйцэтгэгч талуудад санхүүжилтийг бүрэн олгож, санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн,
- Өмнөговь сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр худалдан авсан 0.8 сая, Өндөрхангай сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр худалдан авсан 0.7 сая, нийт 1.5 сая төгрөгийн мэдээллийн сангийн хяналтын программыг данс бүртгэлд тусгаагүй,
- Цагаанхайрхан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 9.9 сая төгрөгийн халуун усны шугамыг данс бүртгэлд тусгаагүй,
- “Чандмань-Увс” ХХК 2020 оны зардлын төлөвлөгөөндөө тусгаадаагүй 6.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байсанд тус тус зөрчил арилгуулах албан шаардлага өглөө.

3.5.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5603.5 сая, эцсийн үлдэгдэл 8182.7 сая төгрөг болж, 2579.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	4657.9	7237.1	2579.2	88.0
Өглөг	29.1	33.9	4.8	
Бусад өглөг	4535.6	7173.3	2637.7	
Урьдчилж орсон орлого	93.2	29.9	-63.3	

Урт хугацаат өр төлбөр дүн	945.6	945.6		12.0
Урт хугацаат зээл	945.6	945.6		
Нийт дүн	5603.5	8182.7	2579.2	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	437.5	343.4	-94.1	4.2
Төсөл, сан	3029.7	5759.1	2729.4	70.4
Төрийн сан	209.2	145.6	-63.6	1.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	1927.1	1934.6	7.5	23.6
ДҮН	5603.5	8182.7	2579.2	100.0

Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 5677.3 сая төгрөгийн барьцаа, төсөвт байгууллагуудын 1460.9 сая, ТӨҮГ-ын 98.9 сая төгрөгийн өр байна.

Барьцаа дансанд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хийгдэж байгаа дуусаагүй ажлын 2456.8 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2020 оны 12 сарын 31-ний өдрийн А/1027 дугаар захирамжийн дагуу байршуулсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 945.6 сая төгрөг нь “Чандмань Увс” ХХК-ийн нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх төслийн хүрээнд АХБ-аас авсан дамжуулан зээлдүүлэх зээлийн өр байна.

Аудитын илрүүлэлт:

Залруулга

- “Шинэ- Улаангом” ОНӨААТҮГ НДШ, цалингийн ашгаас үүссэн 1.2 сая, НӨАТ-ын 9.5 сая төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан,
- Давст сумын Эрүүл мэндийн төв 3.0 сая, Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль 0.1 сая, аймгийн Санхүү хяналт, аудитын алба 0.3 сая, Давст сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 0.4 сая, Сагил сумын Засаг даргын тамгын газар 0.2 сая, Зүүнхангай сумын Хүүхдийн цэцэрлэг 0.9 сая, Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төв 0.1 сая, Ерөнхий боловсролын сургууль 0.5 сая, Тэс сумын Таван улиас багийн бага сургууль 1.6 сая, Өлгий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 0.4 сая, Өндөрхангай сумын Цэцэрлэг 2.2 сая, нийт 11 төсвийн шууд захирагч 9.7 сая төгрөгийн өглөг данс бүртгэлд тусгаагүй байсанд тус тус залруулга хийлгэлээ.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 205456.1 сая, эцсийн үлдэгдэл 230885.8 сая төгрөг болж, 25429.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 11. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

/САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	63169.1	63567.3	398.2	27.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	21708.7	29247.7	7539.0	12.0
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				

Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1680.4	1691.3	10.9	3.0
Хуримтлагдсан үр дүн	71054.0	87959.7	16905.7	38.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47843.8	48419.8	576.0	20.0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	205456.1	230885.8	25429.7	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	174254.9	193017.2	18762.3	83.6
Төсөл, сан	1436.7	1397.9	-38.8	0.6
Төрийн сан	2918.2	3966.0	1047.8	1.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	26846.3	32504.7	5658.4	14.1
Дүн	205456.1	230885.8	25429.7	100,0

Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 63567.3 сая төгрөг болж 398.2 сая төгрөгөөр өссөн аймгийн Хөгжимт жүжгийн театр, Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургуулийн хөрөнгийн өсөлтөөс голлон шалтгаалжээ. Үүнд: Төрийн өмчийн дансны үлдэгдэл 29247.7 сая төгрөг болж 7539.0 сая төгрөгөөр өссөн нь “Чандмань Увс” ХХК 2562.4 сая, “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ 4976.6 сая төгрөгөөр өмчийн дүнг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 48419.8 сая төгрөг болж 576.0 сая төгрөгөөр өссөн нь төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагын хөрөнгийг дахин үнэлж, бүртгэснээс шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 1691.3 сая төгрөг болж 10.9 сая төгрөгөөр өссөн нь Чандмань Увс ХХК-ийн өсөлтөөс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 87959.7 сая төгрөг болж 16905.7 сая төгрөгөөр өссөн нь нэгтгэлд хамрагдсан байгууллага, сангуудын тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.11 Орлогын данстай холбоотой аудитын илрүүлэлт:

Залруулга

- “Чандмань- Увс” ХХК санхүүгийн тайланд дахь орлогыг 9.7 сая төгрөгөөр бууруулан тайлагнасан,
- “Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ санхүүгийн тайланд дахь орлогыг 3.2 сая төгрөгөөр бууруулан тайлагнасан,
- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 13.5 сая төгрөгийг илүү тайлагнасан,
- Өлгий сумын Соёлын төв нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлсэн 0.04 сая төгрөгийн тэтгэмжийн орлогыг үр дүнгийн тайланд тусгасан байсныг тус тус залруулсан.

Төлбөрийн акт

- Завхан сумын Онцгой комисст 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой ард иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас 1.9 сая төгрөгийн хандив бэлэн мөнгөөр ирснийг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй байсанд төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

Тайлант онд дэлхий нийтэд тархаад буй цар тахлын хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хандивласан Өмнөговь сумын ЗДТГ 1.7 сая, Хяргас сумын ЗДТГ 2.9 сая, Цагаанхайрхан сумын ЗДТГ 1.2 сая, Наранбулаг сумын ЗДТГ 2.9 сая, Өлгий сумын ЗДТГ 4.2 сая, нийт 13.2 сая төгрөгийн бэлэн мөнгөний тусламжийг бүртгэлд тусгаагүй Төрийн сангийн хяналтгүйгээр зарцуулсанд зөрчил арилгуулах албан шаардлага өглөө.

3.5.12 Зардлын данстай холбоотой аудитын илрүүлэлт:

Залруулга

- “Шинэ- Улаангом” ОНӨААТҮГ санхүүгийн тайланд дахь зардлыг 3.2 сая төгрөгөөр бууруулан тайлагнасан,
- Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.1 сая, цалингийн зардлыг 1.0 сая, нийт 1.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн суурь” 5.1 дэх хэсэгт “Аж ахуй нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчин Үр дүнгийн тайлангийн зардлыг 3.0 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- Наранбулаг сумын Цэцэрлэг үр дүнгийн тайлангийн хоолны зардлыг 0.03 сая төгрөгөөр илүү, цалингаас суутгасан манхны үнэ 1.5 сая төгрөгөөр цалингийн зардлыг дутуу илэрхийлсэн,
- Наранбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг 1.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн байсан,
- Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн тайланд банкны үйлчилгээний зардал 0.02 сая төгрөгийг мөнгөн гүйлгээ дансанд тусгаагүй байсныг тус тус залруулга хийлгэсэн.

Зөвлөмж

- Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3 дахь хэсэгт "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасныг зөрчин Наранбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль, Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэг болон Улаангом сумын 1, 2, 4, 5, 8, 9, 10, 11, 12 дугаар цэцэрлэгүүдийн эрхлэгч нарт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр нийт 5.3 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- Батлагдсан бүтэц орон тоог хэтрүүлэн ажиллаж Улаангом сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль 10.4 сая, Завхан сумын Засаг даргын Тамгын газар 2.9 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан,
- Малчин сумын Цэцэрлэг нь батлагдсан бүтэц орон тоонд байхгүй ажлыг хавсруулан гүйцэтгүүлж 2.4 сая төгрөг зарцуулсан,
- Сагил сумын Байгаль хамгаалах сангаас хөрөнгө зарцуулах зориулалтыг зөрчиж 0.5 сая төгрөгийг Ковид-19 цар тахлын үеийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед постод ажилласан албан хаагчдын хоолны зардалд зарцуулсан,
- Аймгийн Засаг даргын тамгын газар зарим албан томилолтын хуудсанд очиж ажилласан газраар ажилласан хоногийг таглуулаагүй, буцаж ирэхэд нь томилсон эрх бүхий албан тушаалтан томилолт тооцон олгох хоногийг таглаагүй, гарын үсэг зурж албажуулаагүй, цохолт хийгээгүй,
- Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй,

- Өндөрхангай сумын Засаг даргын Тамгын газар нь Тээвэр шатахууны зардлаас Улаанбаатар хотод албан томилолтоор ажилласан ажилтны замын зардалд 0.1 сая төгрөгийг олгосонд тус тус зөрчил арилгуулах зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт

- Бөхмөрөн сум Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хөрөнгөөр авто зогсоол, гэрэлтүүлэг хийх ажлын зураг төсвийн санхүүжилтийг гэрээний үнийн дүнгээс 1.6 сая төгрөгөөр илүү олгосон,
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр Улаангом сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч 0.4 сая, Тариалан сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн захирал 0.1 сая, нийт 0.5 сая төгрөгийн урамшууллыг өөртөө шийдвэр гарган авсан,
- Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн нягтлан бодогч цалин хөлсийг зөрүүтэй тооцож 3 ажилтанд 0.4 сая төгрөгийг илүү олгосон,
- Хувь хүний орлогын албан татвар суутгахдаа хөнгөлөлтийг хэтрүүлэн тооцож Өндөрхангай сум дахь Сум дундын ойн ангийн нягтлан бодогч С.Сарангэрэлээс 0.2 сая, Өндөрхангай сумын Цэцэрлэгийн нягтлан бодогч Д.Соёлмаагаас 0.2 сая, нийт 0.4 сая төгрөг дутуу суутгаж авсан,
- Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад Ховд сумын ЗДТГ 3 ажилтанд 0.5 сая, Сагил сумын ЗДТГ 1 ажилтанд 0.3 сая, Зүүнхангай сумын Соёлын төв 1 ажилтанд 0.4 сая, нийт 1.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү олгосон,
- Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны А/06 дугаар тушаалаар үйлчлэгч У.Номиндэлгэрийн албан тушаалын цалинг 467374 төгрөгөөр тогтоох байсныг 487695 төгрөгөөр тогтоож 1-6 сар хүртэл цалин олгосон байна. Илүү олгосон цалинг 7-р сарын цалингаас суутгахдаа 0.1 сая төгрөгийг илүү суутгаж авсан,
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг зөрчин Цагаанхайрхан сумын Цэцэрлэг нягтлан бодогч Б.Лхамсүрэнд 2, 3, 4 дүгээр улиралд 1.2 сая, 10, 12 дугаар сард ур чадварын нэмэгдэл 0.4 сая, нийт 1.5 сая, Зүүнхангай сумын Цэцэрлэг сургуулийн нягтлан бодогч Э.Анхбаярт 1 дүгээр улиралд 0.3 сая, О.Энхбаярт 3, 4 дүгээр улиралд 0.6 сая, нийт 0.9 сая, Өндөрхангай сумын Цэцэрлэгийн эрхлэгч Г.Эрдэнэцэцэгт 2-р улирлын урамшуулал 30 хувиар тооцон олгохоор захирамж гарсан байхад 50 хувиар тооцон 0.2 сая, нягтлан бодогч Д.Соёлмаад 2, 3, 4 дүгээр улирлын урамшуулалд 0.7 сая, нийт 0.9 сая, Малчин сумын Цэцэрлэг нягтлан бодогч Ж.Чулуунцэцэгт 2, 4 дүгээр улиралд 0.6 сая, нийт 4.0 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү олгосон,
- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2020 оны 7 дугаар сард 21 албан хаагчийн ээлжийн амралтын нэг өдөрт ногдох цалинг тооцохдоо 10 сарын цалингийн дунджаас тооцож 0.3 сая төгрөгийн ээлжийн амралтын цалинг дутуу олгосон,
- Өлгий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 3.6 сая, шатах тослох материалын зардлаас 911 литр буюу 1.5 сая, нийт 5.1 сая төгрөгийг үндэслэх анхан шатны баримтгүй зарцуулсан,
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нягтлан бодогчоор ажиллаж байсан Э.Гантөгс нь 1-ээс 9 дүгээр сарын цалинг 0.4 сая төгрөгөөр илүү тооцсон, цалингийн урьдчилгаанд олгосон 0.2 сая төгрөгийг суутгаагүй, нийт 0.6 сая төгрөгийг тус тус төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Албан шаардлага

- Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар нь батлагдсан орон тоог 2-оор хэтрүүлэн төсвийн хөрөнгөөс 17.8 сая төгрөг зарцуулсан,
- Наранбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь цар тахалтай холбоотойгоор сумын төвд эргүүл, постод ажилласан төрийн албан хаагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1.2 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- Өлгий сумын Засаг даргын Тамгын газар эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1.5 сая төгрөг зарцуулсан,

- Тэс сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 1.1 сая төгрөг олгосон,
- Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль Увс аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 2962 дугаар захирамжаар С.Батсүхийн ажиллаагүй үеийн Нийгмийн даатгалын шимтгэл 0.8 сая төгрөг төсвөөс төлж, төрийг хохироосон,
- Наранбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль Увс аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2019 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 398 дугаар захирамжаар Б.Алтанзулын ажиллаагүй үеийн цалин 9.8 сая, тэмдэгтийн хураамжийн зардалд 0.4 сая, нийт 10.2 сая төгрөг төсвөөс төлж, төрийг хохироосон байгаа тул аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд албан шаардлага хүргүүлсэн,
- Цагаанхайрхан сумын Цэцэрлэг хүнс тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй хүүхдэд 1.8 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгосон анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй,
- Чандмань Увс ХХК нь Улаанбаатар хотоос томилолтоор ирж ажилласан хүмүүсийн буудлын төлбөрт 0.9 сая төгрөгийг зарцуулсан байсанд тус тус зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 11/2 дугаар тогтоолд зааснаар Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч тайлант онд 9857.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 10794.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 12. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
ТАТВАРЫН ОРЛОГО	9857.9	10794.2	936.3	109.5
Орлогын албан татвар	7856.4	8537.0	680.6	108.66
Хувь хүний орлогын албан татвар	8441.0	9121.6	680.6	108.06
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	6250.0	6497.2	247.2	103.96
Үйл ажиллагааны орлого	160.0	159.1	-0.9	99.44
Хөрөнгийн орлого	1450.0	1358.6	-91.4	93.7
Хөрөнгө борлуулсны орлого	80.0	130.3	50.3	162.88
Шууд бус орлого	501.0	976.3	475.3	194.87
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-584.6	-584.6	0.0	100.0
Хөрөнгийн албан татвар	867.0	811.4	-55.6	93.59
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	461.0	413.10	-47.9	89.61
Бууны албан татвар	46.0	40.70	-5.3	88.48
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	360.0	357.6	-2.4	99.33

Бусад татвар, төлбөр, хураамж	1134.5	1445.8	311.3	127.44
Бусад нийтлэг төлбөр, хураамж	427.0	446.6	19.6	104.59
Улсын тэмдэгтийн хураамж	210.0	185.7	-24.3	88.43
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	42.0	82.7	40.7	196.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	175.0	174.1	-0.9	99.49
Бусад татвар		4.1	4.1	
Газрын төлбөр	590.0	860.5	270.5	145.85
Газрын төлбөр	400.0	860.3	460.3	215.08
Дуудлага худалдаа	190.0		-190.0	0.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	117.5	128.2	10.7	109.11
Ойн нөөц ашигласны төлбөр	72.0	73.5	1.5	102.08
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	13.0	12.2	-0.8	93.85
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	32.5	42.5	10.0	130.77
Бусад татвар		10.6	10.6	
Бусад татвар		10.6	10.6	
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5530.1	1781.9	3,748.2	32.22
Нийтлэг татварын бус орлого	5461.1	1719.3	3,741.8	31.48
Хүүгийн орлого		55.3	55.3	
Торгуулийн орлого	55.0	876.7	821.7	1594.0
Бусад орлого	637.6	787.3	149.7	123.48
Хөрөнгийн орлого	69.0	62.5	-6.5	90.58
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	69.0	62.5	-6.5	90.58

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 936.3 сая төгрөгөөр давсан нь хувь хүний орлогын албан татвар, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, бусад татвар, төлбөр, хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөр, бусад орлого, шууд бус орлогын татвар болон торгуулийн орлого зэрэг орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлснээс шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлт

Тус ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 94689.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 94689.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2285.2 сая төгрөгөөр өсгөж аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 10/04 дугаар тогтоолоор аймгийн 2020 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 96974.8 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд 2020 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор тодотгол хийж 96182.2 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Увс аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 23 хөтөлбөрт зориулан 96182.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 77957.0 сая төгрөгийг урсгал зардалд, 16249.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 1975.6 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 55766.3 сая төгрөгийг улсын, 35261.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 386.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 4768.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 51915.8 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 35907.0 сая төгрөгийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 344.5 сая төгрөг, нийт 88167.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Мөн үндсэн үйл ажиллагааны орлогоос 1397.5 сая төгрөг бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 89456.5 сая төгрөг буюу 93 хувьтай байгаа нь дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахалтай холбоотой Монгол улсын Загийн газрын шийдвэрээр төсөвт байгууллагуудыг хэмнэлтийн горимд шилжин ажилласантай холбоотой байна. Үүнд:

Урсгал зардлын гүйцэтгэлийн материаллаг дүнтэй зардлуудын илүү дутуу зарцуулсан шалтгаануудыг бичих

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 3820.0 сая төгрөгийг улсын болоод орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 126.6 сая, Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-өөс 2092.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2930.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 980.6 сая, нийт 6129.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 4027.9 сая, хөрөнгийн зардалд 1863.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 214.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, арилжааны банк дахь нэмэлт санхүүжилтийн дансанд Улаангом сумын 4 өрхийн Эрүүл мэндийн төв нийт 24.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хамрагдсан 33 төсвийн захирагч нийт 5107 мэдээлэл оруулахаас 5060 мэдээллийг бүтэн жил, хагас жил, улирал болон тухай бүр байршуулсан байна. Ингэхдээ 3995 мэдээллийг хугацаандаа, 1065 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Зарим мэдээллийг байршуулаагүй байгааг нь хуулийн хугацаа болоогүй байна.

Байршуулаагүй мэдээлэл нь:

- Жил эцсийн санхүүгийн тайлан
- Санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлт

Нийт байршуулсан мэдээллийн гүйцэтгэлийн дундаж 99.08 хувьтай байна. Дээрх нэгтгэл хамрагдсан төсвийн захирагч нарын жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад холбогдох зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгсөн болно.

Мөн нэгтгэлд хамрагдсан Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төсөл, хөтөлбөр, тендер худалдан авалт, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, төсвийн

мэдээлэл зэргийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс тухай бүр байршуулан ажигласан байна.

Аудитын илрүүлэлт:

Зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаагүй нийт 3072.4 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан дараах байгууллагуудад зөвлөмж өгсөн.

Үүнд:

- Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 115.3 сая төгрөг
- Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 52.4 сая төгрөг
- Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААН 353.1 сая төгрөг
- Улаангом сумын Соёлын төв 91.7 сая төгрөг
- Өндөрхангай сумын Ахлах сургууль 308.5 сая төгрөг
- Өндөрхангай сумын Соёлын төв 28.9 сая төгрөг
- Тэс сумын Таван улиасны эмнэлэг 115.9 сая төгрөг
- Тэс сумын Хар үзүүрийн эмнэлэг 106.4 сая төгрөг
- Тэс сумын Хүүхдийн цэцэрлэг 102.7 сая төгрөг
- Тэс сумын Эрүүл мэндийн төв 214.1 сая төгрөг
- Зүүнговь сумын Засаг даргын Тамгын газар 15.4 сая төгрөг
- Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 1.1 сая төгрөг
- Орон нутгийн Өмчийн газар 122.3 сая төгрөг
- Завхан сумын Засаг даргын Тамгын газар 42.4 сая төгрөг
- Баруунтуруун сумын Хүүхдийн цэцэрлэг 72.1 сая төгрөг
- Өмнөговь сумын Соёлын төв 98.3 сая төгрөг
- Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургууль 461.9 сая төгрөг
- Тэс сумын Ерөнхий боловсролын сургууль 409.6 сая төгрөг
- Тэс сумын Таван улиасны бага сургууль 71.4 сая төгрөг
- Тэс сумын Хар үзүүрийн бага сургууль 74.7 сая төгрөг
- Тэс сумын Соёлын төв 110.7 сая төгрөг
- Наранбулаг сумын Соёлын төв 103.5 сая төгрөг
- Өлгий сумын Засаг даргын тамгын газар 0 сая төгрөг
- Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 0 сая төгрөг

Албан шаардлага

- Санхүүгийн хяналт, аудитын алба шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31.2 сая төгрөгийн гүйлгээг шийдвэрийн хамт байршуулаагүй, 50 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Хяргас сумын Эрүүл мэндийн төв шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ёстой 566.5 сая төгрөгийн мэдээллийг хугацаандаа мэдээлсэн боловч үнэн зөв байршуулаагүй мөнгөн дүнгийн утгыг 0 төгрөгөөр мэдээлсэн,
- Бөхмөрөн сумын Соёлын төв батлагдсан бүтэц орон тооны мэдээлэл, цалингаас бусад таван сая төгрөг дээш мөнгөн дүнтэй гүйлгээнээс 89.7 сая төгрөгийн 12 гүйлгээ байршуулаагүй,

- Малчин сумын ЗДТГ 2020 оны цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого буюу 365.5 сая төгрөгийн санхүүжилт, удирдлагын шийдвэрээр гарган зарцуулсан 40.4 сая төгрөгийн тушаал, шийдвэр байршуулаагүй,
- Малчин сумын ИТХ 52.9 сая төгрөгийн батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээлээгүй, тушаал шийдвэр гарган зарцуулсан 4.7 сая төгрөгийн мэдээлэл байршуулаагүй,
- Малчин сумын Сум дундын ойн анги батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 46.3 сая, удирдлагын шийдвэр гарган зарцуулсан 1.5 сая төгрөгийн тушаал, шийдвэрийг шилэн дансны сайтад байршуулаагүй байсанд тус тус зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 34.5 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 7/1464 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 13 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	1	34.5	1	34.5			100
Нийт	1	34.5	1	34.5			100

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 19 Төсвийн төвлөрүүлэн захирагч, харьяа 151 төсвийн байгууллага, 23 төрийн /орон нутгийн/ өмчит аж ахуйн нэгж, 58 тусгай сангийн нийт 251 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 170 тайланд дүгнэлт гаргаж, 75 тайланг түүвэрт хамруулж, 6 тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан 159 байгууллага, “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан 9 байгууллага, /Үүнд: аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Зүүнхангай сумын цэцэрлэг, Өлгий сумын ЗДТГ, ИТХ, Өндөрхангай сумын Цэцэрлэг, Хяргас сумын ЭМТ, Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль, Улаангом сумын ИТХ, Ерөнхий боловсролын 4-р сургууль/, “Сөрөг” санал дүгнэлт авсан 2 байгууллага /Үүнд: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч, Өлгий сумын Эрүүл мэндийн төв/ байна. “Санал дүгнэлтээс татгалзсан” дүгнэлт өгсөн байгууллага байхгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 18960.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 14453.7 сая төгрөгийн 107 алдааг аудитын явцад залруулж, 30.0 сая төгрөгийн 24 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1333.9 сая төгрөгийн 31 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 3142.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 47 зөвлөмжийг хүргүүлжээ. Мөн хариуцлага тооцуулах 4 албан шаардлага хүргүүлсэн байна. /Алдаа, зөрчлийг хавсралт судалгаагаар харуулав/

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн дараах зөрчилд залруулга хийлгэсэн. Үүнд:

- Зүүнхангай сумын Сум хөгжүүлэх сангийн өөрийн орлого 0.5 сая төгрөгийг 0.1 сая төгрөгөөр буюу 0.4 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байсныг ҮДТ, МГТ, ТГТ залруулга хийлгэсэн.
- Улаангом сумын Сум хөгжүүлэх сангийн 0.4 сая төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн байсанд СБТ, ҮДТ, ӨӨТ залруулга хийлгэсэн.
- Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 5.1 сая төгрөгийн бусад хөрөнгийн зардлыг МГТ буруу бүртгэгдсэн байсныг залруулга хийлгэсэн.
- Бөхмөрөн сумын Соёлын төвийн 0.6 сая төгрөгийн бусад хөрөнгийн зардлыг МГТ буруу бүртгэгдсэн байсныг залруулга хийлгэсэн.
- Тэс сумын Хүн эмнэлэг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 3.7 сая төгрөгийг өөрийн орлогоор буруу тайлагнасан байсныг МГТ, ТГТ-д залруулга хийлгэсэн.
- Сангийн яамнаас ирүүлсэн шийдвэрээр Ерөнхий боловсролын сургууль болон Цэцэрлэгүүдийн хэмнэлтийн төвлөрүүлсэн 783.5 сая төгрөгийг санхүүжилт болон хоолны зардлыг бууруулж, төвлөрүүлсэн үлдэгдлийн өсгөх өөрчлөлтийг ҮДТ, МГТ, ТГТ-д хийлгэсэн.

Ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага гараагүй болно.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 736.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно. Үүнд:

Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 6.1-д “Захиалагчийн техникийн хяналтын зардлыг нэгдсэн төсвийн тооцооны 2-7 дугаар бүлгийн дүнгээс 2 хувиар тооцно. Нэгдсэн төсөв зохиогдоогүй нөхцөлд барилга угсралтын ажлын төсөвт өртгийн 2 хувиар тооцно” гэж заасны дагуу аймгийн Төрийн сан банкин дахь техник хяналтын 100150000370 тоот дансанд 2020 онд төвлөрүүлсэн техник хяналтын зардлын санхүүжилтийн 736.3 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/311 дугаар захирамжийг үндэслэн 30 хувь буюу 220.9 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг олон нийтэд хүргэх, мэдээлэл сурталчилгаа болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилтай холбоотой бусад зардалд нэрээр, 70 хувь буюу 515.4 сая төгрөгийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд техник, хяналтын зардалд нэрээр хуваарилан шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт техник хяналтын зардлыг хуваарилахдаа ямар нэгэн гэрээ байгуулахгүйгээр олгосон нь хяналт алдагдах, захиалагчийн хяналтын бус ажил үйлчилгээнд зарцуулах эрсдэл үүсгэсэн байна. Тухайлбал:

Аймгийн ЗДТГ нь багаж техник хэрэгсэл, тавилга, урсгал засвар, нэг удаагийн тэтгэмж, цалин, тээвэр шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо интернэт, нормын хувцас, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйл, дотоод албан томилолт, мэдээлэл технологийн үйлчилгээ, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, ном хэвлэл зэрэг зардалд зарцуулсан, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь техник хяналт хийхтэй холбоотой зардлаас гадна Барилгын өргөтгөл, тоног төхөөрөмж, тавилга, урсгал засвар, бусдаар

гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, гэрээтийн цалин, нэг удаагийн тэтгэмж, тэтгэврийн даатгал, бага үнэтэй түргэн элэгдэх зардал, түлш халаалт зэрэгт зарцуулсан байна. Мөн зарцуулаагүй үлдэгдэл 101.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 90.5 сая төгрөгийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн авлага байна. Тухайн авлагыг барагдуулах, найдваргүй авлага болсон бол хууль, тогтоомж, стандартын дагуу данс бүртгэлээс хасахад анхаарч ажиллах.
2. Шилэн дансны тухай хуулийн дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэл хамрагдсан байгууллагууд байршуулах мэдээллээс 1065 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Цаашид шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах нь зүйтэй.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Зардлын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36 дахь заалтад “Төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 14.2.3 дахь заалтад “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, Мөн Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу зарцуулна”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.8-д “Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна”, 2.9-д “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно” гэж заасны зөрчсөн байна. Үүнд:

Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 6.1-д “Захиалагчийн техникийн хяналтын зардлыг нэгдсэн төсвийн тооцооны 2-7 дугаар бүлгийн дүнгээс 2 хувиар тооцно. Нэгдсэн төсөв зохиогдоогүй нөхцөлд барилга угсралтын ажлын төсөвт өртгийн 2 хувиар тооцно” гэж заасны дагуу аймгийн Төрийн сан банкин дахь техник хяналтын 100150000370 тоот дансанд 2020 онд төвлөрүүлсэн техник хяналтын зардлын санхүүжилтийн 736.3 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/311 дугаар захирамжийг үндэслэн 30 хувь буюу 220.9 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг олон нийтэд хүргэх, мэдээлэл сурталчилгаа болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилтай холбоотой бусад зардалд нэрээр, 70 хувь буюу 515.4 сая төгрөгийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот

байгуулалтын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд техник, хяналтын зардалд нэрээр хуваарилан шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт техник хяналтын зардлыг хуваарилахдаа ямар нэгэн гэрээ байгуулахгүйгээр олгосон нь хяналт алдагдах, захиалагчийн хяналтын бус ажил үйлчилгээнд зарцуулах эрсдэл үүсгэсэн байна. Тухайлбал:

Аймгийн ЗДТГ нь багаж техник хэрэгсэл, тавилга, урсгал засвар, нэг удаагийн тэтгэмж, цалин, тээвэр шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо интернэт, нормын хувцас, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйл, дотоод албан томилолт, мэдээлэл технологийн үйлчилгээ, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, ном хэвлэл зэрэг зардалд зарцуулсан, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь техник хяналт хийхтэй холбоотой зардлаас гадна Барилгын өргөтгөл, тоног төхөөрөмж, тавилга, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, гэрээтийн цалин, нэг удаагийн тэтгэмж, тэтгэврийн даатгал, бага үнэтэй түргэн элэгдэх зардал, түлш халаалт зэрэгт зарцуулсан байна. Мөн зарцуулаагүй үлдэгдэл 101.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд Увс аймаг дахь Төрийн аудитын газраас Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар эрх бүхий байгууллагаас захиалагчийн хяналт хийж хугацаатай үүрэг өгсөн боловч өгсөн үүргийн хэрэгжилтийг хангуулдаггүй, төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэдэг, засаж сайжруулах шаардлагатай, дутуу хэрэгжүүлдэг, хугацаандаа хийж дуусгадаггүй зөрчил гарсаар байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 5.4-д "Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна" гэсэн заалт болон "үнэлгээ ба хуваарилалт", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.1.2 Эрсдэл: Захиалагчийн хяналт чанаргүй хийгдэх, зардлыг зориулалт бусаар зарцуулах.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Захиалагчийн хяналтын зардлыг хяналт тавих эрх бүхий байгууллагатай нь гэрээ байгуулан зориулалтын дагуу, үр дүнтэй хуваарилж, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.04.20	Аудитын нэр:	<i>Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код: УВА-2021/01/СТА-ТЭЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч</i>		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал хариуцах албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Холбогдох хууль, тогтоомжийг зөрчин аймгийн Засаг даргын тамгын газар болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт техник хяналтын зардлыг ямар нэгэн гэрээ байгуулахгүйгээр хуваарилж олгосон нь хяналт алдагдах, захиалагчийн хяналтын бус ажил үйлчилгээнд зарцуулах эрсдэл үүсгэсэн байна.	736.3	Зөвлөмж өгсөн	Засаг дарга	Ч.Чимэд
	Дүн				

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

/Б.ОДГЭРЭЛ/
/Т.АМАРМЭНД/

2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр

АУДИТЫН ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГА

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



/Ч.ЧИМЭД/

/Б.ЭРДЭНЭСҮРЭН/

/Б.БАТСАЙХАН/

2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр

УВА-2021/01/СТА-ТЕЗ

